



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: secretariat@parliament.mn  
http://www.parliament.mn

2023.04.20 № ТГ-01/528

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Танилцуулга хүргүүлэх тухай

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-т заасны дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайланг хуульд заасан хугацаанд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайланд шинжилгээ хийж, танилцуулгыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 12 хуудастай.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Л.ӨЛЗИЙСАЙХАН

2023001126



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ  
ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот  
2023 он

## АГУУЛГА

### УДИРТГАЛ

#### **НЭГ.ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ**

#### **ХОЁР.ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ТАЛААР ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

2.1.Гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар холбогдох байгууллагаас гаргуулсан статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх хүрээнд

2.2.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт, шинжилгээ хийх чиг үүргийн хэрэгжилт

2.3.Эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах чиг үүргийн хэрэгжилт

2.4.Судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хамтран ажиллах чиг үүргийн хэрэгжилт

2.5.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах чиг үүргийн хэрэгжилт

#### **ГУРАВ.ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

#### **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

**ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ  
ТАНИЛЦУУЛГА**

**УДИРТГАЛ**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайлангаа Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд ирүүлжээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарыг хүртэлх хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дараах сэдвийн дагуу тайланг боловсруулсан байна. Үүнд:

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хууль, эрх зүйн орчны шинэтгэл;
2. Эрүү шүүлт тулгах, хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах гэмт хэргүүдийн эрх зүйн зохицуулалтын онцлог, статистикт хийсэн дүн шинжилгээ;
3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хяналт, шинжилгээ;
4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа;
5. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн ажил зэрэг болно.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисс (цаашид “ХЭҮК” гэх)-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайланд шинжилгээ хийлээ.

Тайланд шинжилгээ хийхдээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, мөн хуулийн 33-34 дүгээр зүйлд заасан чиг үүрэг, бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлэн ажилласан талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон баримт бичгийн дүн шинжилгээ хийх арга зүйг ашигласан болно.

## НЭГ.ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, 1987 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцоор оролцогч улсуудад эрүү шүүлттэй тэмцэх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтэд өртсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байдаг.

Монгол Улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцод 2000 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр нэгдэн орж, соёрхон баталсан бөгөөд түүний нэмэлт протоколд 2014 оны 12 дугаар сарын 11-ний өдөр нэгдэн орсон билээ.

Монгол Улсын Их Хурлаас 2020 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, "эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх" гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан, цогц үйл ажиллагааг хэлнэ гэж заасан. Уг хуулиар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний бүрэн эрх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгасан.

Мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна." гэж заасан хүрээнд 2022 онд ХЭҮК-ын нийт төсвийн 6.1%-ийг (2022 оны 08 дугаар сараас хойш), 2023 онд 9.8%-ийг (2023 оны 04 дүгээр сар хүртлэх хугацаанд) тус тус эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр дараах чиг үүргийг заасан байдаг. Үүнд:

- аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт<sup>1</sup> эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх;
- олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах;
- эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах;
- хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 29 дүгээр тогтоолоор ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг томилсон бөгөөд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу түүнд туслах чиг үүрэг бүхий нэгжийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс ажиллаж байна.

## **ХОЁР.ХУУЛЬД ЗААСАН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН ТАЛААР ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

**2.1. Гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар холбогдох байгууллагаас гаргуулсан статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх хүрээнд:**

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан “Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан, нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагаас гаргуулах болон бусад хэлбэрээр хамтран ажиллана.” гэж заасан үйл ажиллагааг мөн хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.7-д заасан “эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашгийн төлөө бус хуулийн этгээд болон бусад байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох...” эрхийн хүрээнд зохион байгуулжээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дүрэм”-ийн 8.1.4-т “Комисст гаргасан эрүү шүүлттэй холбоотой гомдол мэдээлэл, түүний шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх...” гэж заасны дагуу *Прокурорын байгууллагаас* эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хамгаалах ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны холбогдогчдын статистик мэдээлэл, мөн 2017-2022 онд хууль бусаар баривчлах, саатуулах, ялгаварлан гадуурхах, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хүрээнд хэрэг бүртгэлийн хэрэг нээн шалгасан талаарх статистик мэдээлэл, *Цагдаагийн байгууллагаас* цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдаас эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, ялгаварлан гадуурхахтай холбоотой гэмт хэрэг, зөрчил, ёс зүйн зөрчилд шалгагдсан байдал, тэдгээрийн шийдвэрлэлтийн статистик мэдээллүүдийг авч, дүн шинжилгээ хийсэн байна.

Мөн ХЭҮК-т 2016-2023 оны 03 дугаар сар хүртэл хугацаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний халдашгүй байх эрхтэй холбоотой иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн талаар тайланд тусгажээ.

Тайлангаас үзвэл, 2016 оноос 2023 оны 03 дугаар сар хүртэлх хугацаанд ХЭҮК-т эрүү шүүлтээс ангид байх 225, хууль бусаар баривчлах 63, хууль бусаар цагдан хорих 321 буюу нийт 609 гомдлыг иргэн, албан тушаалтнаас ирүүлсэн байна.

Гэвч тайланд “гэмт хэргийн нөхцөл байдал”, “гэмт хэргийн шалтгаан, нөхцөл”-ийн талаарх мэдээлэлд хийсэн дүн шинжилгээний талаар тодорхой дурдаагүй байна.

**2.2. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт, шинжилгээ хийх чиг үүргийн хэрэгжилтийн талаар:**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй бүх газарт<sup>1</sup> эрүү шүүлт гарч болзошгүй тогтолцооны шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор тогтмол хяналт шинжилгээ хийх” гэж, мөн “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дүрэм”-ийн 8.1.3-т хэлтсийн албан хаагчид нь “аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, эсхүл тухайн этгээд өөрийн хүсэлтээр

<sup>1</sup> Тайлбар: Энэ хуульд заасан “бүх газарт” гэдэгт хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, сэтгэцийн эрүүл мэндийн төв, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байрыг ойлгоно.

гарч явах боломжгүй газарт хяналт шинжилгээ хийх” гэж заасан.

Энэ хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний баталсан “Хяналт шинжилгээ хийх удирдамж”-ийн дагуу нэг байгууллагад дунджаар 3-5 өдөрт багтаан зохион байгуулж, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, зарим тохиолдолд нэгжийн дарга ахалж, гүйцэтгэдэг байна.

Хяналт шинжилгээг “ахуй нөхцөл”, “эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрх”, “хөгжиж сурч боловсрох эрх”, “эрүү шүүлтээс ангид, халдашгүй чөлөөтэй байх” зэрэг эрхийг хангаж байгаа эсэхийг судлан тогтоох хүрээнд НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооноос гаргасан жишиг аргачлалын дагуу тухайн байгууллагын нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцах, удирдлага, албан хаагч, цагдан хорих ангид эрх нь хязгаарлагдсан хүнтэй биечлэн уулзаж ганцаарчилсан ярилцлага хийх, амаар болон бичгээр тайлбар авах, холбогдох баримт бичигтэй танилцах, шаардлагатай тохиолдолд хуулбарлан авах, дуу, дүрсний болон бусад техник хэрэгслийг ашиглан баримтжуулж, түүврийн аргаар санал асуулга авч, дүн шинжилгээ хийж ажилласан байна.

Тайлант хугацаанд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх **хяналт шинжилгээг дараах 23 байгууллагын хүрээнд гүйцэтгэн, нийт 1954 хүнээс асуумж авч, 202 эрх чөлөө нь хязгаарлагдсан хүн, 48 ажилтан, албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага** хийсэн байна. Хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилтийг баталгаажуулан ажилласан байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийсэн хяналт шинжилгээг: ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, баривчлах байр, Говьсүмбэр аймаг дахь ШШГГ-ын 425 дугаар нээлттэй хорих анги, Төв аймгийн Баян сумын ШШГГ-ын 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Дундговь, Өмнөговь аймаг дахь ШШГГ-ын цагдан хорих, баривчлах байрууд, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өмнөговь аймаг дахь ШШГГ-ын цагдан хорих байр, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГ хэлтсийн 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги;
2. Цагдаагийн байгууллагад хийсэн хяналт шинжилгээг: Нийслэлийн цагдаагийн газрын харьяа Эрүүжүүлэх, саатуулах төв, Говьсүмбэр, Өмнөговь, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Архангай, Завхан аймаг болон Тосонцэнгэл сумын сум дундах цагдаагийн хэлтэст;
3. Төв аймгийн Батсүмбэр суман дахь Ахмад настны Үндэсний төв;
4. Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвийн Шүүхийн сэтгэц, эмгэг судлалын клиникт, Асрамжийн тасгуудад тус тус хяналт шинжилгээг хийсэн байна.

Харин Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасан байгууллагаас хүүхдийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах болон хамгаалах байруудад одоогоор эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шинжилгээг гүйцэтгээгүй байна.

Дээрх байгууллагуудад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шинжилгээг гүйцэтгээгүй нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгжийн хүний нөөцийн хязгаарлагдмал хүчин чадлаас шалтгаалсан бөгөөд энэ талаар нэмэлт мэдээлэл авахад Сангийн яамнаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022-2023 оны төсвийг (нийт 11 орон тоо, цалингийн сан батлагдсан байснаас) 5 орон тоо, цалингийн санг хасаж, үйл ажиллагааны урсгал зардлыг бууруулан төлөвлөж, Улсын Их Хурлаар батлуулсан

байна. Түүнчлэн тус нэгжийн бүрэн эрхээ хэрэгжүүлээд удаагүй, дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа нь бүрэн жигдрээгүй зэрэгтэй холбоотой байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар товч дурдвал:

### **1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага:**

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цагдан хорих болон хорих ангид сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй иргэний анхан шатны мэдээллийг цуглуулан оношлон тодорхойлох, дарамт, стрессээс гарахад нөлөөлөх, нөхөн сэргээх, тусламж үзүүлэх дохионы хэлмэрчийн мэдлэгтэй албан хаагчтай байх шаардлагатай байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд “хоригдсон этгээдтэй хүнлэг бус харьцах”-ыг хориглосон боловч хоригдогчийн биед халдах, хэл амаар доромжлох, зодох зэрэг гэмт хэргийн шинжтэй гомдлууд гарсаар байна.
- Хууль зүй, дотоод хэргийн болон Эрүүл мэндийн сайдын 2017 оны А-240/А-369 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Эмнэлэгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”-ын 5.1-д “Хамгаалалтын нэг ээлжид 3-аас доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулна.” гэснийг зөрчин нэг албан хаагчаар хамгаалалтын үүрэг гүйцэтгүүлсэн.
- Цагдан хорих анги, хорих ангиудад хоригдож буй хүмүүсийн наад захын хэрэгцээ шаардлагыг хангахаар худалдаалагдаж буй зөвшөөрөгдсөн бараа, бүтээгдэхүүний үнэ харилцан адилгүй, хадгалах хугацаа дууссан, ялангуяа, эмэгтэйчүүдийн хэрэгцээт бүтээгдэхүүний хангалт, сонголт, чанар муу байдгаас үүдэлтэй эрүүл мэндэд сөрөг үр дагавар гарах эрсдэлтэй.
- Хорих ангид эмчийн хүний нөөц дутмаг байгаа нь эмнэлэгийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй үзүүлэхэд бэрхшээлтэй, нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдах, эмчлүүлэх эрх хэрэгжихгүй байх, эмийн чанар, хүртээмж хангалтгүй байгаад анхаарах шаардлагатай.
- Баривчлах байрны бие засах газар бохир, яр шарх, хатги, бөөстэй, архинд донтсон хүмүүсийг тусгаарладаггүй, хоолны амт чанар маш муу, эмнэлэгийн тусламж, үйлчилгээг хангалтгүй үзүүлдэг, бүхэл мөнгөний хариулт өгдөггүй, өндөр үнээр бүтээгдэхүүн зардаг зэргээр хүний эрх зөрчигддөг зэрэг байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хийсэн хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн ШШГЕГ-ын дарга, Цагдан хорих 461 дүгээр ангийн болон Баривчлах байрны даргад зөвлөмж хүргүүлсэн байна.

### **2. Цагдаагийн байгууллага:**

- Хордлого тайлах эмчилгээг төлбөртэй хийдэг учир согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, хордлогод орсон тэнэмэл болон төлбөрийн чадваргүй, бичиг баримтгүй, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийг дүүргийн нэгдсэн эмнэлэгт хүргэж өгөхөд хүлээн авахаас татгалздаг.
- Зарим эрүүлжүүлэх саатуулах байр стандарт шаардлага хангадаггүй, үйлчлэгчийн орон тоо байхгүй, цэвэрлэгээ үйлчилгээ туйлын хангалтгүй, эм тариа авах төсөв, мөнгө дутагдалтай, камерын хяналтыг сайржуулах, агааржуулалтын систем байхгүй, халаалтын систем шаардлага хангахгүй зэрэг болно.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Төв аймгийн Цагдаагийн газрын даргад зөвлөмж хүргүүлсэн байна.

### **3. Ахмад настны Үндэсний төв:**

- Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хуулийн үйлчлэл хамаарахгүй



хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн тулгамдсан асуудалтай иргэнд асрамжийн үйлчилгээ үзүүлж байна. Иймд эдгээр иргэдэд асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаатай холбогдуулан сэтгэцийн эмч, хэл засалч ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

- Ахмад настнууд Нийгмийн халамжийн тухай хууль, захиргааны хэм хэмжээний актад тусгагдсан “асруулагч” нэршилд эмзэгшилтэй хандаж, улмаар нийгэмд тогтсон сөрөг хандлагаас шалтгаалан гэр бүлийн гишүүд, төрөл садан, найз нөхөд, ажлын хамт олноос өөрийгөө тусгаарлан харилцаа холбоо тогтоохоос татгалзах, ялангуяа өөрийн нэр төр, алдар хүндийг эрхэмлэн Үндсэн хуульд баталгаажсан итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр илэрхийлэхгүй байх шалтгаан болж байна.
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т “... хүүхэд ба иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга гаргана.” гэж заасныг хяналт шинжилгээний явцад ахмад настнууд төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага бие даан шийдвэрлэх нь зүйтэй гэсэн саналыг гаргасан.
- Явган хүний зам, талбайн төлөвлөлтийг стандартын шаардлагад нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдлыг хангах орчныг бүрдүүлэх зэрэг болно.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдад тус тус зөвлөмж хүргүүлсэн байна.

#### **4. Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төв:**

- Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон захиргааны хэм хэмжээний актад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тогтоосон, тодорхойлсон ойлголт тусгагдаагүй байгаа нь мөрдөгч, прокуророос шинжээч томилсон тогтоолд асуулт тавигддаггүй, шинжээчийн дүгнэлтэд тусгагддаггүй, шүүхийн тогтоолд хэрэглэдэггүй нөхцөл байдал хяналт шинжилгээний явцад тогтоогдсон.
- Шүүхийн шийдвэрээр эмнэлгийн чанартай албадан эмчилгээ хийлгэж байгаа эрэгтэй, эмэгтэй, өсвөр насны эмчлүүлэгчид болон сэтгэц судлалын шинжилгээ хийлгэж байгаа хүнийг нэг дор, нэг жижүүрт, тусгаарлах хаалгагүй тасалгаанд байрлуулан, албадан эмчилж байгаа нь сэтгэцийн эмгэгтэй эмчлүүлэгчид, эмч, эмнэлгийн ажилтнуудын амь нас, эрүүл мэнд, аюултай байдалд орж болзошгүй эрсдэлтэй нөхцөл үүссэн байна.
- Мөн тус төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудтай хийсэн бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаар ажлын ачаалал их, хэт ачаалалтай олон цагаар ажилладаг, ажил үүрэгтэй холбоотой ямар нэг хадлагад өртөх, эрүүл мэндээрээ хохирох, эмчлүүлэгчээс хэл амаар доромжилдог, нийгмийн баталгаа хангалтгүй байгаа зэрэг асуудлуудыг хэлсэн.
- Эмэгтэй албадан эмчлүүлэгчдийн биед үзлэг хийх, өвчний учраас нарийн мэргэжлийн эмчид хандаж, клиникээс бусад газар үзлэг, оношилгоо хийлгэх, шинжилгээ өгөх, хэвтэн эмчлүүлэх тохиолдолд ижил хүйсийн харуул хамгаалалтын ажилтангүй, түүнчлэн харуул хамгаалалтын алба хаагчид тус төвийн эрэгтэй, эмэгтэй ажилтнууд хамтдаа нэг өрөөнд хувцасаа сольдог нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан Эрүүл мэндийн салбар дахь Жендэрийн эрх тэгш байдлын баталгааг зөрчсөн байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь хяналт шинжилгээгээр тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд болон Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвийн захиралд тус тус зөвлөмж хүргүүлсэн байна.

### ***2.3.Эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах чиг үүргийн хэрэгжилт:***

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т “олон нийтэд эрүү шүүлтийн хор аюулыг тайлбарлан таниулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг төрийн албан тушаалтан, иргэдэд сурталчлах” гэж заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтуудыг иргэд, төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудад эрүү шүүлтээс ангид байх эрх, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх талаарх сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, шаардлагатай зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан байна.

Тайланд прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Ахмад настны Үндэсний төвийн албан хаагчид, нийгмийн хамгааллын салбарын төрөлжсөн асрамжийн газрын ажилтнууд, СЭМҮТ-ийн ажилтнууд зэрэг нийт 3357 албан тушаалтан, ажилтан, алба хаагчдад эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан талаар дурдсан байна.

Сургалт, сурталчлан таниулах үйл ажиллагааны дийлэнхийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаа, прокурорын байгууллага зэрэг хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад чиглэсэн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулжээ. Харин Ахмад настны Үндэсний төвийн албан хаагчид, нийгмийн хамгааллын салбарын төрөлжсөн асрамжийн газрын ажилтнууд, СЭМҮТ-ийн ажилтнуудад болон иргэд олон нийтэд хандсан сургалтыг зохион байгуулсан талаар нарийвчлан дурдаагүй байна.

Энд дурдахад нэгжийн албан хаагчид нь хууль, эрх зүйн чиглэлээр багшилж байсан туршлагатай байгаа нь сургалтыг үр дүндтэй явуулах, чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд хэмжээний эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой байна.

Цаашид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нээлттэй болон хаалттай хорих анги, баривчлах байранд цагдан хоригдож байгаа болон Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1-д заасны дагуу аливаа хэлбэрээр хүний эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан, эсхүл өөрийн хүсэлтээр гарч явах боломжгүй газарт байгаа иргэд, эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд, түүний ар гэрийнхэнд эрүү шүүлтийн хор аюулын талаарх мэдлэг, мэдээлэл олгох, эрүү шүүлтээс ангид байх эрхээ хамгаалах чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, танин мэдэхүйн арга хэмжээг зохион байгуулахад анхаарч, үр дүнд чиглэсэн агуулга бүхий хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### ***2.4.Судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хамтран ажиллах чиг үүргийн хэрэгжилт:***

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3-т “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, сургалт, сурталчилгааны хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах зэрэг ажлыг эрхлэн явуулах, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг оролцуулах” чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ.

Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд “сурталчилгааны хэрэглэгдэхүүн”, “гарын авлага боловсруулах” чиглэлээр Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протокол, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сурталчлан таниулах, түгээх зорилгоор иргэд, олон нийтэд чиглэсэн танилцуулга, видео бэлтгэх, холбогдох гарын авлага боловсруулах ажлыг аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэсэн байна.

Түүнчлэн “сургалтын хөтөлбөр” боловсруулах хүрээнд Истанбулын протоколд нийцүүлэн боловсруулж, хууль сахиулах байгууллагын албан хаагчдаас гадна эмнэлгийн мэргэжилтэн, бусад холбогдох байгууллагын ажилтнуудыг сургах, сургалтын чанар, хүртээмжийг хөндлөнгийн хараат бус байгууллагаар үнэлгээ хийлгэх чиглэлээр анхаарч ажиллаж, авах арга хэмжээний талаар тайланд дурджээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны сурталчилгааны хэрэглэгдэхүүн, гарын авлага боловсруулах, цахим хуудсаар олон нийтэд түгээх ажлуудын хувьд хэрэгжүүлэх шатанд байгаа бөгөөд харин эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар судалгаа хийх, ном, товхимол боловсруулах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайланд тодорхой дурдаагүй байна.

Цаашид мөрдөгч, прокурор, шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, алба хаагчдын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц болон бусад олон улсын гэрээ конвенцын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх талаар сургалтын цогц хөтөлбөртэй болгох, сургалтыг давтан болон байнгын болгон тогтмолжуулах шаардлагатай байна.

Хүний эрхийг хамгаалах, дэмжихэд нэг чухал оролцогч нь иргэний нийгмийн байгууллага бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комисс түүнтэй нягт, идэвхтэй хамтран ажиллах шаардлагатайг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 48/134 дүгээр тогтоолоор баталсан Хүний эрхийн үндэсний байгууллагуудын эрх зүйн байдлын талаарх зарчим буюу Парисын зарчимд онцолсон билээ.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайланд дурдсанаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.8-т заасны дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь “Эрүүл шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх” бүрэн эрхийнхээ хүрээнд НҮБ-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо болон НҮБ-ын хүний эрхийн тогтолцоонд хамаарах бусад байгууллагатай хамтран ажиллахад анхаарч ажилласан байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиг үүргийнхээ хүрээнд зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаагаа “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын шаардлагад нийцүүлэн явуулахад анхааран ажиллаж, бүс нутгийн болон олон улсын сүлжээ байгууллагатай олон талт түншлэлийг хөгжүүлэх, Үндэсний урьдчилан сэргийлэх байгууллагуудын бүсийн уулзалтад оролцох, ялангуяа хүний эрх чөлөөг хязгаарлагдсан газруудад хяналт тавих аргачлалын талаар туршлага солилцоход чиглэсэн олон улсын уулзалт, үйл ажиллагаануудад идэвхтэй оролцож байна.

### ***2.5.Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах чиг үүргийн хэрэгжилтийн талаар:***

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4-т “хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах” чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайланд дурдсанаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний болон түүний нэгжийн хуулиар хүлээсэн чиг үүрэг, хэрэгжилтийн явц, зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгтэй холбоотой мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудас, болон хандалт ихтэй мэдээллийн сайтууд, сонин, телевизээр холбогдох ярилцлага, мэдээллийг өгөх зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээж ажилласан талаар тусгасан байна.

Түүнчлэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт шинэчлэлтийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор холбогдох танилцуулга, видео контентыг бүтээж, телевизүүдээр түгээсэн байна.

## **ГУРАВ.ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д "... байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаа нь эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар шийтгэх буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж болзошгүй гэж үзвэл шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд зөвлөмж хүргүүлнэ." гэж заасан.

Энэ хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт, шинжилгээний явцад тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн **нийт 12 зөвлөмжийг** холбогдох албан тушаалтанд хүргүүлснээс Засгийн газрын гишүүдэд давхардсан тоогоор 6 удаа, дэд сайдад 1 удаа, асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтанд 2 удаа, тухайн байгууллагын удирдах албан тушаалтанд 4 удаа тус тус зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй" гэж, мөн зүйлийн 35.3-т "Байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд нь зөвлөмжийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэрэгжүүлсэн талаар бичгээр хариуг мэдэгдэнэ." гэж заасан.

Тайланд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох албан тушаалтан зохих хариуг ирүүлсэн гэж дурдсан хэдий ч зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх хариуг хуульд заасан хугацаанд ирүүлсэн эсэх болон хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнд дүн шинжилгээ хийсэн эсэх талаар тусгаагүй байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2022 оны тайлан"-д шинжилгээ хийлээ.

Уг тайлан нь 2022 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хамруулсан бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, түүний нэгж нь хуульд заасан чиг үүргээ богино хугацаанд хэдий ч үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай 33 дугаар зүйлийн 33.1-д заасны чиг үүргийг дээрх хугацаанд хэрэгжүүлсэн талаар зохих мэдээллийг тайланд тусган ирүүлжээ. Түүнчлэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, тэдгээрийг хэрэгжүүлэгч байгууллагаас гарсан санал, зөвлөмжид нийцүүлж, Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахаар зорьж ажилласан байна.

## ЗӨВЛӨМЖ

Шинжилгээний үр дүнд тулгуурлан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт, түүний үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон төсвийн тооцоо судалгааг нарийвчлан гаргаж, саналыг эрх бүхий байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх талаар зохих арга хэмжээг авч ажиллах;  
Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны төсөв нь чиг үүргээ бүрэн, тасралтгүй, үр нөлөөтэй, хараат бусаар эрхлэн явуулахад хүрэлцэхүйц байна.” гэж заасны дагуу хүний нөөцийн болон эдийн засгийн хувьд хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.
2. Эрүү шүүлт, ялангуяа, эрүүдэн шүүх, хууль бусаар баривчлах, хууль бусаар цагдан хорихтой холбоотой иргэн, албан тушаалтны гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэхэд анхаарах, уг асуудлыг нарийвчлан судалж, эрх бүхий байгууллагад танилцуулах, шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллах;
3. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан чиг үүргийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнд суурилсан төлөвлөлт хийж, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахад анхаарах;
4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнд тогтмол дүн шинжилгээ хийж, энэ талаар цаашид тайланд тусгах;
5. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний зөвлөмжийн хариуг холбогдох байгууллагууд хуульд заасан хугацааны дотор ирүүлсэн боловч зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний явц, үр дүнг тайланд тодорхой дурдаагүй байгаад анхаарах;
6. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн хяналт шинжилгээний хүрээнд тогтоогдсон нөхцөл байдлыг дахин гаргахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авч ажиллах, шаардлагатай тохиолдолд давтан хяналт шинжилгээ хийх.

--- оОо ---